

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРГИЙН ХАЙГУУЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛЖ, 2022 ОНЫ ӨРӨМДЛӨГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2022.04.13

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монгол Улсын баруун урд зүгт Хөндий Алтны Дүүрэг (“Дүүрэг”)-т 2022 оны хайгуулын хөтөлбөрийн эхний үе шатыг эхлүүлж байгааг танилцуулахад таатай байна. Энэхүү хайгуулын хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий исэлдсэн алтны бүсүүдийг судлан, Алтан Нар алтны төслийн үргэлжлэл, 2021 онд нээн илрүүлсэн Баян Хөндий алтны төсөл (“Баян Хөндий”)-ийн Хар Морь болон Улаан нээлтийн өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийг тэлэх зорилготой. Хөтөлбөрийн эхний үе шат нь 10,000 метр алмазан өрөмдлөг ба 3,000 метр эргэлтэт-цохилтын өрөмдлөг (“RAB”)-өөс бүрдэнэ.

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: “2022 оны Хөндий хайгуулын хөтөлбөрийн эхний үе шат нь өнгөрсөн улирлын хайгуулын амжилттай үр дүнгүүдэд суурилна. 2021 онд Хар Морь талбайд газрын дөт гүнд маш өндөр агуулга бүхий исэлдсэн алтны хүдэржилт тодорхойлж, Зүүн Өмнөд Улаан нээлтэд өндөр агуулга бүхий бүсүүдийг агуулсан зузаан алтны хүдэржилтийн интервалууд илрүүлсэн. Эдгээр нээлтүүд нь Баян Хөндийн илээр олборлох боломжтой алтны ордоос 2.5 км-т оршиж, Баян Хөндий алтны нээлтийн хүдэржилттэй холбоотой ижил интрузивийн нэг хэсэг юм.”

“Энэ оны хайгуулын хөтөлбөрөөр шинэ нээлтүүдээс гадна Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 16 км-т орших Алтан Нар алтны ордын эрдэсжилтийг тэлэх боломжтой өндөртэй байгаа тул хайгуулын ажлуудыг үргэлжлүүлнэ. Эдгээр ордууд нь илээр олборлох боломжтой их нөөцтэй хэмээн тодорхойлогдохоос гадна газрын дөт гүнд, өндөр агуулгатай алтны хүдэржилт гэдэг утгаараа онцлогтой. Бид Хөндий дүүрэг нь олон сая унц алтны нөөц бүхий ордуудыг агуулах боломжтой хэмээн таамаглаж, 2022 оны эцэст хоёр сая унц алттай дүйцэх нөөцийг баталгаажуулах зорилт тавьсан. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр бид зорилтын хүрээнд нөөцийг нэмэгдүүлэх боломжтой гэж итгэж байна.”

Хөндий Дүүрэг 2022 оны хайгуулын хөтөлбөр болон төслүүдийн тухай

2022 оны 2-р улирлын хайгуулын хөтөлбөр нь Баян Хөндий, Алтан Нар алтны ордуудын тэлэлт, 2022 оны хоёрдугаар хагаст хийх нарийвчилсан хайгуулын хөтөлбөр нь шинэ бүсүүдийг тодорхойлоход чиглэнэ. Баян Хөндийн Хар Морь,

Улаан талбайд хэд хэдэн хүдэржсэн өндөр хэтийн төлөв бүхий бүс тодорхойлсон ч өрөмдлөгийн судалгаа хийгдээгүй байгаа ба Алтан Нар нь судлын дагуу болон гүндээ нээлттэй хэвээр байна. Түүнээс гадна газрын дөт гүнд исэлдсэн алтны хүдэртэй холбоотой хэд хэдэн бүсүүдийг судлах шаардлагатай.

2022 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн эхний үе шат нь 10,000 метрийн алмазан өрөмдлөгөөр эхлэн, удаах сараас 3,000 метрийн RAM өрөмдлөгөөр үргэлжилнэ. Эхний үе шат нь 2-р улирлын турш үргэлжилнэ. Эхний үе шатны үр дүнгүүдэд тулгуурлан дараагийн үе шатны хөтөлбөрийг загварчлахаар төлөвлөсөн.

2-р улирлын хайгуулын хөтөлбөрийн чиглэх бүсүүд:

- Баян Хөндий – Улаан:
 - Огтлогч структурын дагуу тэжээгч бүс байх боломжтой, нээлтийн хойд зүгт маш өндөр агуулгатай алтны бүсүүдийн (UDH-21 цооногт 156.5 г/т алтны агуулга хүртэл) хайгуул
 - 8.74 г/т алтны агуулга бүхий 27 метр (UDH-21) ба 5.43 г/т алтны агуулга бүхий 34 метрийн (UDH-14) үр дүн илэрсэн Зүүн Өмнөд Улаан талбайн өндөр агуулга бүхий зузаан бүсүүдийг тодорхойлох, тэлэх хайгуул
 - Зүүн Өмнөд Улаан талбайн тэлэлтийн өрөмдлөгүүд, тэр дундаа гурван өргөтгөлийн цооног гүндээ алтны хүдэржилтээр төгссөн
 - Улаан тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд ба баруун хэсэгт алт болон геофизикийн аномаль шинж чанар бүхий хэтийн төлөв бүхий талбайд өрөмдлөг хийнэ.
- Баян Хөндий – Хар Морь:
 - 2021 онд 195 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон (AAD-178) Хар Морийн Дэл бүсэд газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий исэлдсэн бүсүүдийг тэлэх судалгаа
 - Геофизикийн зорилтот бүсүүдийн дагуу газрын дөт гүнд өндөр агуулга бүхий исэлдсэн алтны хүдэржилтийг доош унасан тэлэлтийн дагуу судлах
 - Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд гүний болон гүехэн хүдэржилтийн өрөмдлөгийн хөтөлбөр
- Газрын дөт гүнд исэлдсэн алтны хайгуул (Баян Хөндий):
 - Хар Морийн Дэл хайгуулын хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр Улаан болон Хар Морь талбайд алтны хүдэржилттэй холбоотой исэлдсэн болон баяжсан бүсүүдийг судлах RAB өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлнэ
 - Өнгөрсөн саруудад геологийн баг өгөгдөл цуглуулан, үнэлгээ хийснээр RAB өрөмдлөгийн хөтөлбөрийг тодорхойлсон ба хэтийн төлөв бүхий талбайд 150-200 ширхэг гүехэн (10-20 метр) цооногуудыг өрөмдөнө.
- Алтан Нар – Нээлтийн бүс

- Алтан Нар Нээлтийн Бүсийн судалгаа хийгдээгүй талбайд хүдэржилт үргэлжилж байгааг 2020 оны 1-р улиралд танилцуулсан. Өрөмдлөгөөр 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга болон 3.40% цайр 7 метрийн турш (TND-135) огтолсон.
- Нээлтийн Бүсэд газрын гадаргын алтны боломжууд нь газрын дөт гүнд исэлдсэн алттай холбоотой.
- Алтан Нар – Хойд Холбоо
 - Гадаргын алтны хүдэржилтийн баяжилттай холбоотой газрын дөт гүний исэлдсэн алтны өндөр агуулга бүхий бүсийг шалгах үргэлжилсэн хайгуул хийгдэнэ.

Төслүүдийн тухай

Хөндий Дүүрэг нь Транс Алтайн Террейн (Хуучнаар Эдрэнгийн Террейн)-д 40км*20км талбайд гүехэн субдукцын Палеозойн интрузив үйл явдалтай холбоотой гурван алт болон суурь металлын системд тулгуурладаг. Эрдэнэ Ресурсийн 2022 оны хайгуулын хөтөлбөр нь дараах хоёр алтны системд чиглэнэ:

Баян Хөндий: Бага сульфид эпитеpmаль алтны орд болон хэтийн төлөв бүхий талбай (Баян Хөндий орд, Хар Морийн Дэл, Улаан болон Алтан Сум) нь өндөр агуулга, интрузив хамааралтай хувирлын бүсээр тодорхойлогддог. 12 км трендийн дагуу байрладаг ордуудыг бүс нутгийн тэлэлтийн бүс болон судлын хагарлын системийн дагуу зүүн хойд трендийн структурт чиглэсэн гүн бүтэцтэй холбоотой хэмээн тайлбарладаг. Баян Хөндий алтны ордын нөөц: 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)³ тодорхойлогдсон. Хар Морийн Дэл, Улаан болон Алтан Сум талбайд нөөцийн тооцоолол хийгээгүй байна.

Алтан Нар (Golden Sun): Дундаж сульфид, карбонатлаг суурь металлын алтны орд ба хэтийн төлөв бүхий талбай нь Хойд-Зүүн хойд тренд структурын коридорт багтдаг геохимийн аномаль хувирлын бүсэд 5.6 км урт талбайг хамран оршдог. Олон структурын огтлол нь тэлэлтийн бүсийг үүсгэж, хүдэржилтийн өргөн бүсүүд бий болох нөхцөлийг бүрдүүлсэн. Алтан Нарын нөөцөд 2.0 г/т алтны агуулга бүхий 317,700 унц бодитой нөөц, 1.7 г/т алтны агуулга бүхий 185,700 унц боломжтой нөөц тодорхойлогдсон.

Баян Хөндий Хар Морийн Дэл болон Улаан нээлтийн тухай мэдээллийг Алтан Нар төслийн тоймтой хамт доор харуулав.

¹Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

²Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

³Батлагдсан & Магадласан: 4.4 г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадласан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу. !

Хар Морийн Дэл

Эрдэнэ Ресурс нь 2021 оны эхээр Баян Хөндий ордоос хойд зүгт 2.4 км-т өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэснээр Хар Морийн Дэл бүсийг илрүүлсэн. Баян Хөндий ордоос хойд зүгт 2.4 км-т орших энэ бүс нь газрын гадаргаас эхэлдэг бөгөөд өмнө зүгт 20-60 метрийн босоо гүнд өргөн, хагарлын дагуу гүндээ исэлдэн, 123 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал (AAD-178) зэрэг маш өндөр алтны агуулга бүхий бүсийг агуулсан супергенээр баяжсан талбайд хамаардаг. Өндөр агуулга бүхий исэлдсэн хүдрийн биет нь хойд-өмнөд судлын дагуу үргэлжилж байгааг харуулсан. Хүдэржилт нь судлын дагуу болон гүндээ нээлттэй. Хязгаарлагдмал хийгдсэн гүний өрөмдлөгөөр алтны хүдэржилтийн зузаан бүсүүдийг (жишээ нь AAD-57, цооногийн 194 метрт 1.18 г/т алтны агуулга бүхий 48 метр) огтолсон нь эпитеpmаль судал, цагаан гялтгануурын хувирал болон сульфидын хүдэржилттэй холбоотой бөгөөд эрдэсжсэн бүсийг тэлэхэд нээлттэй хэвээр байна.

Компани нь 2021 оны эцэс, 2022 оны эхэнд Хар Морь талбайд өгөгдөл цуглуулах, тайллын судалгаа болон өрөмдлөгийн хөтөлбөр тодорхойлох ажлуудыг гүйцэтгэсэн. Энэхүү ажлууд нь алтны аномализм, тэжээгч структурыг тодорхойлох, гүехэн алтны исэлдсэн хүдэржилт, Хар Морийн Дэлтэй ижил чанартай талбайг тодорхойлох болон алтны хүдэржилтийн гүний бүсүүдийг тодорхойлоход чиглэсэн. Дээрх судалгаагаар 2022 онд судлах хэд хэдэн өрөмдлөгийн талбайг ялгасан.

Улаан

Улаан нээлтийг 2021 оны 3-р улиралд гадаргын эрдэсжилтгүй нөхцөлд нээн илрүүлсэн. Нээлт нь 200м*250 метрийн талбайг хамарсан хэдэн зуун метр (354 метр хүртэл) алтны хүдэржилтээр тодорхойлогддог. Алтны хүдэржилт нь 80 метрийн гүнээс эхэлдэг, баруун-баруун хойд зүгт судлын дагуу болон гүндээ нээлттэй. Үүнд UDH-22 (85 метрээс) цооногт 1.7 г/т алтны агуулга бүхий 152 метр, UDH-21 (115 метрээс) 3.2 г/т алтны агуулга бүхий 77 метрийн интервалууд огтолсон.

Талбайн зүүн талд хэдэн зуун метрт орших Баян Хөндий эпитеpmаль алтны ордын шинж чанартай ижил, маш өндөр агуулга бүхий кварц ± гематит, адулярын судал болон цагаан гялтгануурын хувиралтай лапилли туфтай ижил зузаалагт агуулагдаж буй штокверк бүсээр тодорхойлогддог.

156.5 г/т хүртэл алтны агуулга нь агуулагч структур болон тэжээгч бүсүүдтэй холбоотой кварц±гематитын судлууд, штокверк бүсүүдэд тохиолдоно. Улаан нээлтийн хойд хэсэгт илрүүлсэн штокверк бүс нь 2022 оны 2-р улирлын хайгуулын бүс болох бөгөөд 20 г/т алтны агуулга бүхий 5 метр (UDH-14), 156 г/т алтны агуулга бүхий 1 метр (UDH-21) интервалууд агуулсан өргөн бүсүүд болох 8.74 г/т алтны агуулга бүхий 27 метр (UDH-21), 5.43 г/т алтны агуулга бүхий 34 метр (UDH-14) бүхий цооногуудын чиглэл болон цар хүрээг тодорхойлохоор зорьсон. Түүнээс гадна 2022 оны хайгуулын хөтөлбөрөөр Зүүн Өмнөд Улаан талбайд өргөтгөлийн өрөмдлөгөөр одоогийн байгаа цооногуудыг гүндээ үргэлжилж буйг шалгах хэд хэдэн өрөмдлөг гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Улаан тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд хэсэгт 3.5км*1км талбайд аномаль хөрсний алт бүхий бүсүүд байдаг. Суурь геологи, хувирлаас харахад Зүүн Өмнөд Улаан, Баян Хөндийн алтны хүдэржилт нь цагаан гялтгануур болон цахиурын хувирал бүхий туфын нэгжүүдтэй төстэй. Энэхүү өндөр хэтийн төлөв бүхий талбайг шалгах хэд хэдэн цооног өрөмдөнө.

Алтан Нар

Алтан Нар нь Баян Хөндий ордоос хойд зүгт 16км зайтай оршдог, дундаж сульфид, карбонат-полиметаллт алтны (CBMG) орд бөгөөд нийт 5.6 км системийн трендээс бүрддэг бөгөөд гүндээ болон суналын дагуу нээлттэй. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба эрдэсжилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.

Алтан Нарын бодитой нөөцийн дийлэнх нь Нээлтийн Бүсэд байрладаг бөгөөд үлдсэн хэсэг нь Хойд Холбоод байрлаж байна. 2022 оны хайгуулын хөтөлбөрийн эхний үе шатны зорилт нь нөөцийг нэмэгдүүлэх болон газрын дөт гүний исэлдэлтийг судлахад оршино.

Нээлтийн бүсэд урьд нь өрөмдлөг хийж байгаагүй талбайд (“Gap Zone”) өндөр агуулга бүхий цөмийг судлахаар хийсэн өрөмдлөгийн хөтөлбөр (2019)-өөр эпитеpmаль буцлалтын бүсийг илтгэх өндөр агуулга бүхий алтны хүдэржсэн талбайг тодорхойлсон. Үүнд 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсноос 7 метрийн интервал нь 80 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135) нь өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүнд тооцогдож байна.

Энэхүү бүсийг тэлэхэд чиглэсэн нарийвчилсан өрөмдлөг гүйцэтгэнэ. Өндөр агуулга бүхий огтлолуудын зарим нь бага агуулга бүхий нөөцийн блок эсвэл түүний гадна байрлаж байгаа бөгөөд Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлэх боломжтой. Нэмэлт өрөмдлөгөөр газрын дөт гүнд супергенээр баяжсан алтны бүсийг судлах, Нээлтийн Бүстэй зэрэгцээ орших структур болон судлын дагуу үргэлжилж буйг судална. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн нь Алтан Нарын нөөцөд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Хойд Холбоо нь Нээлтийн Бүсээс хойш 1.2 км зайд оршдог бөгөөд гадаргын чулуулгын дээжлэлтээр маш өндөр алтны хүдэржилт, суваг малталтаар 20.25 г/т алтны агуулга бүхий 7 метр илрүүлсэн (ANT-14). Алмазан өрөмдлөгөөр гүндээ нарийссан бүсүүдийг тодорхойлсон. Хар Морийн Дэл дэх суперген баяжуулалтын ойлголтыг нэмэгдүүлснээр нимгэн хурдас дор, газрын дөт гүнд хүчтэй исэлдэлт байгааг баталсан. Энэ талбай болон Алтан Нарын 5.6 км хүдэржсэн трендийн дагуу зорилтот талбайг супергенээр баяжсан/ исэлдсэн алтны бүс эсэхийг үнэлэх бөгөөд алмазан болон RAM өрөмдлөг хийгдэнэ.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Компани нь Баян Хөндий, Хар Морь, Зүүн Өмнөд Улаан талбайд төвлөрөн ажилласан тул Алтан Нар төсөлд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн. Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайн багахан хэсэгт өрөмдлөгийн

судалгаа хийгдсэн. Түүнээс гадна 2018 онд RPM Global компанийн боловсруулсан NI 43-101 эрдсийн нөөцийн 90% нь газрын гадаргаас 150 метрт, 18 хэтийн төлөвт талбайн 2-т төвлөрсөн бөгөөд бүх бүсүүд нь гүндээ болон судлын дагуу нээлттэй хэвээр байна.

Суперген исэлдэлсэн алтыг тодорхойлох

RAM өрөмдлөгөөр 2021 онд Хар Морийн Дэлд (195 г/т алтны агуулга бүхий 1 метр) илрүүлсэнтэй адил газрын дөт гүнд, исэлдсэн алтны бүсүүдийг шалгах бөгөөд Баян Хөндий, Улаан болон Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайд илрүүлсэн залуу нөмрөг хурдсаар бүрхэгдсэн талбайг туршина. Энэхүү өрөмдлөгөөр гүехэн RAM өрөмдлөгийг (10-20 метр) гүйцэтгэх бөгөөд энэ нь алмазан өрөмдлөгтэй харьцуулахад хурдан бөгөөд өртөг бага.

RAM өрөмдлөгийг Хөндий болон Улаан тусгай зөвшөөрлийн талбай болон Хар Морь талбайд гүйцэтгэнэ. Алт агуулсан исэлдсэн бүсүүд нь Хөндий Алтны Дүүргийн хөрсний элэгдлийн түвшин, гидрологи, агаар мандал нь гүн исэлдэлт, супергенээр баяжсан алтны хүдэржилт үүсгэх таатай нөхцөл үүсгэсэн. Энэ нь Хөндий Дүүрэгт газрын дөт гүн, өндөр агуулга бүхий алтны хүдэржилт нэмж илрүүлэх боломжтойг харуулж байна.

Хөндий алтны дүүрэг

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. 2021 онд Компани нь Хар Морь болон Улаан шинэ алтны хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон.

Баян Хөндийд 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц⁴ (“Measured and Indicated Resources”)⁵, 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)⁶ тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс

⁴Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээгээс танилцана уу.

⁵Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

⁶Батлагдсан & Магадласан: 4.4 г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадласан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу. !

танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурсийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 2, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд

үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419



TSX: ERD | MSE: ERDN

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

!

!

! " # \$ % & ' () * % ' % & + , - & . , ' / 0 1 0 2 0 0 ' 3 4 5 *) - 6 , &) \$ ' (# & % 3



! "#\$% &'() *%'+(, *- .%/ -.

/ 010200'3H I D7=8971%@J878;8971%8=>9?@:A


6C;D7'\$D:' : 0,3'#,/)2'-2)#+' (+37 *+',,) 3\$+ - /3&)3 () ; /)3/ &3/ *) (03&' * /) (.)32/) * / . '% / *) 6' & 1 (5 / + 7) 9 (% /) . (10&' % -) (%) * / # (&' 3) / " # \$ % &' (% <) & 0 + . \$ 1 /) (" ' * /) = (% /) * / . '% ' 3' (%) \$ % *) % / 4 * ' & 1 (5 / + ' / &

%8=>9?@:A'B97@'' 6+',, '%-)3 ()3\$+ - /3) 32/) 10++ / % 3, 7) 0 % 3 / & 3 / *) / 0 1 2 & 3 ' 4 + 5 & 4 ' 3 2' %) 3 2 /) 1 (+ /) (.) 3 2 /) 5 / + 7) 2' - 2 8 - + \$ * /) 6' & 1 (5 / + 7) 9 (% /) * / # (&' 3

#7897'\$9:;<' " # \$ % &' (%) * +',, '%-) (.) % / \$ +) & 0 + . \$ 1 /) 2' - 2) - + \$ * /) (" ' * /) + , \$ 3 / *) - (, *) 4 2 / + /) # + / 5' (0 &) 3 + / % 1 2' % -) + / 3 0 + % / *) (5 / + ! " # \$ % & # ' () &' * + , & - . &

9*\$C8%3(9''''(D'8+'\$C(E\$'+.#*%+ F!>(9''''(D'8+'\$C(>82%3\$';

! "#\$%



4%*8%(&8'#1(



9*/-8:.';(<8%.



B;2# 012%3**

%D:F' " 9:=@'GD7@ 6+',, '%-)3 ()3/ & 3) * (4 %) * ' # / " 3 / % &' (%) (.) 5 / + 7) 2' - 2 8 - + \$ * /) & 0 + . \$ 1 /) (" ' * /) - (, *) = (% /) \$ 3) B (0 3 2) : \$ % /) < . &' 7 & = ! ; 9 < & # \$ % & # ' () & > ? % @ ? 4 & = < . &' 7 & : ! 9 8 & # \$ % H I) J K D) * +',, '%-) 3 () 3 / & 3) 0 % * / +) 1 (5 / +) . (+) \$ * * ' 3' (% \$,) % / \$ +) & 0 + . \$ 1 /) (" ' * /) - (, *)

#CDD7 +9E;<@D=; 6'-2)#+' (+37)+"#\$%&' (%) \$ % *) * / . '% ' 3' (%) * +',, '%- . (10&' % -) (%) 1 (% 3' % 0 \$ 3' (%) (.) 3 2 /) 3 2' 1 > <) 2' - 2 8 - + \$ * /) - (, *) % 3 / + & / 1 3 / *) %) , \$ 3 /) ? @ ? A) 2' - 2 , ' - 2 3 / *) ; 7) ! - . &' 7 & 8 9 - : & # \$ % & # ' () & 1 4) & ; : . &' 7 & < 9 : ; & # \$ % & # ' ()

+9E;<'#CDD7 B1(03)*+',, #+ (-+\$C). (10&'%-) (%) - + / % . ' / , *) / " # , (+ \$ 3' (%) 3 \$ + - / 3 &) 1 (% &' & 3' % -) (.) & 0 + . \$ 1 /) - (, *) \$ % (C \$, / &) 2 (& 3 / *) 4 ' 3 2' %) \$, 3 / + / *) 5 (, 1 \$ % ' 1) + (1 > &) &' C , \$ +) 3 () D \$ 7 \$ %) E 2 0 % * ')) \$ % *) F , \$ \$ % B !

012%3**) *%'+(, *- .%/ -.

4"\$\$\$% 567'8'\$#\$8%(, *- .%/ -.

4"\$\$\$% =82#1

9\$'@(A8' / . () \$%.

4"\$\$\$% =82#1. \$ / #

>\$; \$%(012%3** ?8'3(9.78/ #

